

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: САГ-2026/29/НА-СТА-ТЕЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Д.Баярсайхан Утас: 261663 Цахим хаяг: <a href="mailto:bayarsaikhand@audit.gov.mn">bayarsaikhand@audit.gov.mn</a> Аудитын менежер: С.Нацагдорж Утас: 260512 Цахим хаяг: <a href="mailto:natsagdorjs@audit.gov.mn">natsagdorjs@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Г.Оюунтөгөлдөр Утас: 261729 Цахим хаяг: <a href="mailto:oyuntuguldurg@audit.gov.mn">oyuntuguldurg@audit.gov.mn</a> Аудитор: Д.Батчимэг Утас: 261729 Цахим хаяг: <a href="mailto:batchimegda@audit.gov.mn">batchimegda@audit.gov.mn</a> Аудитор: Э.Булганчимэг Утас: 261729 Цахим хаяг: <a href="mailto:bulganchimege@audit.gov.mn">bulganchimege@audit.gov.mn</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	4
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	20
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	24
4.1 Ерөнхий зүйл .....	24
4.2 Материаллаг байдал.....	25
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	25
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..	26
4.4.1 Албан шаардлага .....	29
4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	31
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	31
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	32
5.1 Харьяа байгууллагууд .....	32
5.2 Төсвийн ерөнхийлөн захирагч .....	32
5.3 Түүвэрт хамрагдсан байгууллагууд.....	33
5.3.1 Зөвлөмж .....	33
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	36

## Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын
ИХАШТШТГ	Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн Тамгын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын стандарт
ШТГ	Шүүхийн тамгын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭХАШТШТГ	Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн Тамгын газар



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГА П.ЗОЛЗАЯА ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30  
Цахим шуудан: info@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.27 № 1146  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Шүүх байгуулах тухай хуулийн дагуу Дүүргийн Эрүү, Иргэний хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс байгуулан ажилласнаар эрүүгийн 1,336, иргэний 28,611, зөрчлийн 22,410 нийт 52,357 хэрэг хянан шийдвэрлэсэн байна.

**Аудитын гол асуудлын хэсэг**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Шүүхийн үйл ажиллагааны чанар, хүртээмжийг сайжруулах хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хан-Уул дүүрэг дэх шүүхийн цогцолбор барилга, Архангай, Дархан-

Уул, Өмнөговь аймаг болон Баянзүрх, Багануур дүүрэгт шүүхийн зориулалттай нийт 6 барилгын ажлыг хэрэгжүүлж байна. Эдгээр төсөл, арга хэмжээнд тайлант онд 46,764.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 38,389.3 сая төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл 82.0 хувьтай байна.

### **Бусад асуудал**

“Шүүхийн үйлчилгээний стандарт”-ыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны 40 дүгээр тогтоолоор, “Шүүхийн байрны стандарт”-ыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны 15 дугаар тогтоолоор тус тус батлуулж, Стандарт, хэмжил зүйн газарт байгууллагын стандартаар бүртгүүлсэн байна.

Шүүхийн хараат бус байдал хангагдаж, хариуцлагатай, иргэн төвтэй шүүх тогтолцоо төлөвшүүлэх Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, цахим засаглал, дижитал шилжилтийн хүрээнд “Цахим шүүх 2.0” цөм системийг 2025 онд албан ёсоор нэвтрүүлэн ажилласан байна. Тус системийн хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны системийн таслан сэргийлэх арга хэмжээ, зөрчлийн хэрэг шүүхэд шалган шийдвэрлэх ажиллагааны модулийг эрүүгийн хэргийн анхан шатны 32 шүүхийн үйл ажиллагаанд ашиглаж эхэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй болно.

### **Санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

## 2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>24,437,664.0</b>	<b>9,106,139.9</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>13,017,533.2</b>	<b>1,749,161.1</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>24,113.5</b>	<b>102,306.1</b>
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>3,177,529.6</b>	<b>2,372,202.3</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>8,218,487.8</b>	<b>4,882,470.4</b>
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>58,074,498.1</b>	<b>117,875,698.1</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>58,074,498.1</b>	<b>117,875,698.1</b>
39200	Биет хөрөнгө	52,693,207.6	101,453,577.7
39300	Биет бус хөрөнгө	5,381,290.5	16,422,120.3
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>	<b>82,512,162.2</b>	<b>126,981,838.0</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,410,151.9</b>	<b>4,230,759.4</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,410,151.9</b>	<b>4,230,759.4</b>
41300	Өглөг	2,410,151.9	4,230,759.4
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>80,102,010.2</b>	<b>122,751,078.6</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>80,102,010.2</b>	<b>122,751,078.6</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	21,988,610.0	23,889,780.9
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	21,988,610.0	23,889,780.9
51200	Хуримтлагдсан үр дүн	45,087,560.5	85,915,866.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	13,025,839.7	12,945,430.9
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>	<b>82,512,162.2</b>	<b>126,981,838.0</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>167,589,630.3</b>	<b>244,285,436.8</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,261,975.9</b>	<b>244,285,436.8</b>
122	Тусламжийн орлого	-	242,586,499.5
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>164,327,654.3</b>	<b>-</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>145,063,952.3</b>	<b>201,650,080.1</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>145,063,952.3</b>	<b>201,650,080.1</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	127,209,663.0	187,020,833.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	95,469,962.4	141,048,705.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,993,060.6	17,676,376.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,245,475.5	6,550,677.9
2104	Хангамж, бараа материалын зардал	5,565,925.2	6,083,961.1
2105	Нормативт зардал	34,514.2	10,230.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,134,137.4	5,303,023.3
2107	Томилолт, зочны зардал	653,946.1	703,358.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,034,859.9	2,655,278.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,077,781.7	6,989,223.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,854,289.3	14,629,247.0
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>22,525,678.0</b>	<b>42,635,356.7</b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>42,561.6</b>

V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,314.7	9,439.7
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(2,314.7)	33,121.9
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	22,523,363.2	42,668,478.6

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөг/

Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>57,367,460.2</b>	-	<b>57,367,460.2</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	38,948.0	-	38,948.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	57,406,408.2	-	57,406,408.2
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(38,948.0)	-	(38,948.0)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	211,186.8	-	211,186.8
Тайлант үеийн үр дүн	22,523,363.2	-	22,523,363.2
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>80,102,010.2</b>	-	<b>80,102,010.2</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,835,406.5	-	1,835,406.5
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	81,937,416.8	-	81,937,416.8
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(1,854,816.9)	-	(1,854,816.9)
Тайлант үеийн үр дүн	42,668,478.6	-	42,668,478.6
<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>122,751,078.6</b>	-	<b>122,751,078.6</b>

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөг/

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>177,666,781.6</b>	<b>244,824,704.8</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>13,374,275.3</b>	<b>244,824,704.8</b>
120	Нийтлэг татварын бус орлого	13,374,275.3	2,272,849.1
122	Тусламжийн орлого	-	242,551,885.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	164,292,506.3	-
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>148,420,008.1</b>	<b>201,503,318.2</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>148,420,008.1</b>	<b>201,503,318.2</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	130,592,961.2	186,801,118.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	95,505,905.2	141,026,365.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,975,472.2	17,703,378.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,694,041.5	6,749,309.8
2104	Хангамж, бараа материалын зардал	5,289,893.9	5,531,056.3
2105	Нормативт зардал	64,657.5	19,953.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,026,403.2	10,092,434.6
2107	Томилолт, зочны зардал	671,486.3	654,817.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,789,911.9	2,607,141.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	575,189.5	2,416,661.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,827,046.9	14,702,199.6

<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>29,246,773.5</b>	<b>43,321,386.6</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>16,608,100.2</b>	<b>54,589,758.6</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>16,608,100.2</b>	<b>54,589,758.6</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	16,608,100.2	54,589,758.6
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(16,608,100.2)</b>	<b>(54,589,758.6)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>12,638,673.3</b>	<b>(11,268,372.1)</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	378,860.0	13,017,533.2
<b>20</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>13,017,533.2</b>	<b>1,749,161.1</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>I</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>276,306,531,900.00</b>	<b>233,692,218,076.86</b>	<b>42,614,313,823.14</b>	<b>84.6</b>
<b>12</b>	<b>Татварын бус орлого</b>	<b>276,306,531,900.00</b>	<b>233,692,218,076.86</b>	<b>42,614,313,823.14</b>	<b>84.6</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>510,000,000.00</b>	<b>155,900,766.67</b>	<b>354,099,233.33</b>	<b>30.6</b>
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	510,000,000.00	155,900,766.67	354,099,233.33	30.6
122	Тусламжийн орлого	275,796,531,900.00	233,536,317,310.19	42,260,214,589.81	84.7
122005	Төсвөөс санхүүжих	275,796,531,900.00	233,536,317,310.19	42,260,214,589.81	84.7
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>276,306,531,900.00</b>	<b>233,536,317,310.19</b>	<b>42,770,214,589.81</b>	<b>84.5</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	223,557,931,900.00	189,162,963,802.59	34,394,968,097.41	84.6
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>205,254,838,600.00</b>	<b>183,394,053,042.94</b>	<b>21,860,785,557.06</b>	<b>89.3</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>146,253,253,000.00</b>	<b>139,474,060,550.41</b>	<b>6,779,192,449.59</b>	<b>95.4</b>
210101	Үндсэн цалин	83,587,322,300.00	86,518,023,387.61	(2,930,701,087.61)	103.5
210102	Нэмэгдэл	35,788,311,900.00	32,308,323,986.78	3,479,987,913.22	90.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,176,384,000.00	11,282,621,247.17	893,762,752.83	92.7
210104	Урамшуулал	14,701,234,800.00	9,365,091,928.85	5,336,142,871.15	63.7
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>18,399,802,400.00</b>	<b>17,506,108,855.96</b>	<b>893,693,544.04</b>	<b>95.1</b>
210201	Тэтгэврийн даатгал	12,487,456,900.00	11,969,303,800.72	518,153,099.28	95.9
210202	Тэтгэмжийн даатгал	1,449,475,000.00	1,393,824,717.38	55,650,282.62	96.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	847,115,800.00	732,468,510.80	114,647,289.20	86.5
210204	Ажилгүйдлийн даатгал	723,150,600.00	674,587,522.20	48,563,077.80	93.3
210205	Эрүүл мэндийн даатгал	2,892,604,100.00	2,735,924,304.86	156,679,795.14	94.6
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>7,963,204,700.00</b>	<b>6,749,309,818.99</b>	<b>1,213,894,881.01</b>	<b>84.8</b>

**Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит**

210301	Гэрэл, цахилгаан	1,080,228,900.00	862,131,105.41	218,097,794.59	79.8
210302	Түлш, халаалт	1,848,516,800.00	1,573,239,083.80	275,277,716.20	85.1
210303	Цэвэр, бохир ус	285,085,900.00	193,999,619.81	91,086,280.19	68.0
210304	Байрны түрээс	4,749,373,100.00	4,119,940,009.97	629,433,090.03	86.7
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,320,781,400.00</b>	<b>5,461,800,980.93</b>	<b>858,980,419.07</b>	<b>86.4</b>
210401	Бичиг хэрэг	2,441,945,000.00	1,805,375,106.60	636,569,893.40	73.9
210402	Тээвэр, шатахуун	1,106,385,500.00	984,542,577.75	121,842,922.25	89.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,783,142,200.00	1,739,727,293.78	43,414,906.22	97.6
210404	Ном, хэвлэл	23,146,200.00	18,361,600.00	4,784,600.00	79.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	59,201,200.00	41,912,756.00	17,288,444.00	70.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	906,961,300.00	871,881,646.80	35,079,653.20	96.1
2105	Нормативт зардал	69,202,000.00	19,953,800.00	49,248,200.00	28.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	69,202,000.00	19,953,800.00	49,248,200.00	28.8
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>20,614,643,700.00</b>	<b>10,253,203,872.41</b>	<b>10,361,439,827.59</b>	<b>49.7</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,583,869,700.00	1,771,637,963.00	3,812,231,737.00	31.7
210602	Тавилга	9,723,687,500.00	4,077,524,190.00	5,646,163,310.00	41.9
210604	Урсгал засвар	5,307,086,500.00	4,404,041,719.41	903,044,780.59	83.0
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>1,156,981,400.00</b>	<b>654,817,437.00</b>	<b>502,163,963.00</b>	<b>56.6</b>
210701	Гадаад албан томилолт	145,745,800.00	128,214,070.00	17,531,730.00	88.0
210702	Дотоод албан томилолт	1,011,235,600.00	526,603,367.00	484,632,233.00	52.1
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,524,556,100.00</b>	<b>2,553,465,726.89</b>	<b>971,090,373.11</b>	<b>72.4</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,163,262,500.00	630,402,760.51	532,859,739.49	54.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,530,000.00	3,226,000.00	3,304,000.00	49.4
210803	Даатгалын үйлчилгээ	1,600,554,400.00	1,541,271,417.50	59,282,982.50	96.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	33,245,800.00	20,685,692.88	12,560,107.12	62.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	15,021,500.00	3,640,700.00	11,380,800.00	24.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	654,109,100.00	327,102,656.00	327,006,444.00	50.0
210807	Газрын төлбөр	51,832,800.00	27,136,500.00	24,696,300.00	52.4
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>952,413,900.00</b>	<b>721,332,000.35</b>	<b>231,081,899.65</b>	<b>75.7</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	469,483,000.00	375,381,730.35	94,101,269.65	80.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	482,930,900.00	345,950,270.00	136,980,630.00	71.6

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>18,303,093,300.00</b>	<b>5,768,910,759.65</b>	<b>12,534,182,540.35</b>	<b>31.5</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>18,303,093,300.00</b>	<b>5,768,910,759.65</b>	<b>12,534,182,540.35</b>	<b>31.5</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	659,597,400.00	640,944,956.00	18,652,444.00	97.2
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,589,000.00	3,300,000.00	3,289,000.00	50.1
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,762,714,000.00	4,498,198,341.05	12,264,515,658.95	26.8
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	593,430,400.00	411,520,041.60	181,910,358.40	69.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	280,762,500.00	214,947,421.00	65,815,079.00	76.6
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>52,748,600,000.00</b>	<b>44,373,353,507.60</b>	<b>8,375,246,492.40</b>	<b>84.1</b>
220001	Барилга байгууламж	46,764,400,000.00	38,389,252,007.60	8,375,147,992.40	82.1
222001	Тоног төхөөрөмж	5,984,200,000.00	5,984,101,500.00	98,500.00	100.0
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	155,900,766.67	(155,900,766.67)	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(155,900,766.67)	155,900,766.67	-
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(155,900,766.67)	155,900,766.67	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	4,520.00	4,492.00	28.00	99.4
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>34.00</b>	<b>40.00</b>	<b>(6.00)</b>	<b>117.6</b>
610001	Төсвийн байгууллага	34.00	40.00	(6.00)	117.6
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	2,199.00	2,226.00	(27.00)	101.2
620001	Удирдах ажилтан	167.00	149.00	18.00	89.2
620002	Гүйцэтгэх ажилтан	1,345.00	1,513.00	(168.00)	112.5
620003	Үйлчлэх ажилтан	687.00	564.00	123.00	82.1
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>2,199.00</b>	<b>2,226.00</b>	<b>(27.00)</b>	<b>101.2</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	904.00	972.00	(68.00)	107.5
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	1.00	30.00	(29.00)	3000.0
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	60.00	53.00	7.00	88.3
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	9.00	8.00	1.00	88.9
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	25.00	8.00	17.00	32.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	570.00	661.00	(91.00)	116.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7.00	6.00	1.00	85.7

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

650012	Шүүгч, прокурор	599.00	483.00	116.00	80.6
650014	Төрийн үйлчилгээний мэргэжлийн (ТҮМ)	24.00	5.00	19.00	20.8
<b>66</b>	<b>НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ</b>	<b>88.00</b>	<b>-</b>	<b>(88)</b>	<b>-</b>
660001	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	88.00	-	(88)	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>-</b>	<b>2,390,964,071.05</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>-</b>	<b>2,390,964,071.05</b>
122	Тусламжийн орлого	-	2,390,964,071.05
1221	Хандив тусламж /дотоод/	-	2,390,964,071.05
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	2,390,964,071.05
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,367,656,236.95
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	23,307,834.10
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>-</b>	<b>2,365,588,736.35</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>2,365,588,736.35</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	2,364,588,736.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	1,552,304,864.34
210101	Үндсэн цалин	-	159,876,968.00
210102	Нэмэгдэл	-	1,184,104,221.34
210104	Урамшуулал	-	208,323,675.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	197,270,066.01
210201	Тэтгэврийн даатгал	-	148,690,004.87
210202	Тэтгэмжийн даатгал	-	12,324,055.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	7,022,708.64
210204	Ажилгүйдлийн даатгал	-	5,260,482.17
210205	Эрүүл мэндийн даатгал	-	23,972,815.11
2104	Хангамж, бараа материалын зардал	-	69,137,500.00
210401	Бичиг хэрэг	-	41,115,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	3,700,000.00
210404	Ном, хэвлэл	-	170,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	24,152,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	490,880,306.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	105,164,400.00
210602	Тавилга	-	27,000,000.00
210604	Урсгал засвар	-	358,715,906.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	32,126,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	32,126,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	22,870,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	12,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	10,870,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	1,000,000.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	25,375,334.70
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(25,375,334.70)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(25,375,334.70)

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал**

Шүүхийн ерөнхий зөвлөл “Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасан 5 чиг үүргийн хүрээнд үйл ажиллагааны чиглэл, эрхэм зорилго, зорилтуудыг тодорхойлсон байна.

Шүүхийн ерөнхий зөвлөл нь эрхэм зорилгоо “Шүүхийн хараат бус байдлыг хангаж, хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг хамгаалах” гэж тодорхойлсон байна.

Шүүхийн ерөнхий зөвлөл шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүх бүрэлдэхүүнээс хэрэг маргааныг шийдвэрлэхэд мэдээлэл, судалгаа, санхүү, аж ахуй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэн ажиллах нөхцөлөөр хангах үндсэн чиг үүрэгтэй.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга нь үйл ажиллагааны тэргүүлэх 5 чиглэл, эрхэм зорилгын хүрээнд хэрэгжүүлэх 5 зорилтын хүрээнд 113 арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталж, гүйцэтгэлийг 91.0 хувиар тайлагнасан байна.

#### **3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин**

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм, журмуудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Нэмэлт өөрчлөлт орсон хуулийн жагсаалт:

- Монгол Улсын шүүхийн тухай хууль;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль
- Эрүүгийн хууль
- Зөрчлийн тухай хууль
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Авлигын эсрэг хууль
- Төсвийн тухай хууль
- Хууль тогтоомжийн тухай хууль
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай

Нэмэлт өөрчлөлт орсон дүрэм, журам, стандарт, аргачлалын жагсаалт:

- Захиргааны хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлал, загвар батлах тухай
- Иргэний хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлал, загвар батлах тухай
- Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журам батлах тухай
- Шүүгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах аргачлал батлах тухай
- Шүүх хуралдаанд оролцогчийг зайнаас буюу цахимаар оролцуулах ажлыг зохион байгуулах журам батлах тухай
- Анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийн 2023 оны ажлын зохист ачаалал тогтоох тухай
- Шүүгчийг шилжүүлэн томилуулах журам батлах тухай
- “Эрүүгийн хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлал”
- “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгдэх баримтын загвар”-ыг шинэчлэн батлах тухай

2025 онд шинээр батлагдсан дүрэм, журам, стандарт, аргачлалын жагсаалт:

- Шүүхийн байрны стандарт батлах тухай
- “Шүүгч, шүүхийн захиргааны ажилтанд буцалтгүй тусламж олгох журам”-ыг батлах тухай
- “Шүүхийн хэргийн индексийн журам”-ыг шинэчлэн батлах тухай
- Шүүхийн үйлчилгээний стандарт батлах тухай
- Шүүгчийн хувийн хэрэг хөтлөх журам
- Шүүгчийн ажлын бодит ачааллыг тооцох аргачлал батлах тухай
- Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх иргэний хэрэг, таслан сэргийлэх арга хэмжээ, зөрчлийн хэргийн хөдөлгөөний түр аргачлал батлах тухай
- Системд хандах эрхийн удирдлагын зохицуулалтын журам батлах тухай
- Шүүх, шүүхийн Тамгын газарт албан хэрэг хөтлөх журам шинэчлэн батлах тухай

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, дотоод аудитаар хийсэн ажлын тайлан, илрүүлэлт болон дүгнэлт, зөвлөмжөөс харахад дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжсэн гэж үзлээ. Тухайлбал:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь тайлант онд 3 зорилтын хүрээнд 20 арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны 25 дугаар тогтоолоор биечилсэн аудитын төлөвлөгөөг батлуулж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын баталсан удирдамжийн дагуу 7 шүүхийн Тамгын газрын үйл ажиллагаанд төлөвлөгөөт аудит, 1 шүүхийн Тамгын газарт төлөвлөгөөт бус аудит хийж, 157.9 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, 1.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэн, 1 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах

саналыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх, хуурамч бичиг баримт үйлдсэн байж болзошгүй 1 зөрчлийг Цагдаагийн байгууллагад шилжүүлэх саналыг тус тус хүргүүлсэн. Шүүхийн ерөнхий зөвлөлийн хуралдаанд 7 шүүхийн Тамгын газрын үйл ажиллагаанд хийсэн аудитын тайланг танилцуулж, хурлын шийдвэрийн дагуу зөрчлийг арилгах, үйл ажиллагааг сайжруулах хүрээнд 5 чиглэл тус бүрээр нийт 337 заалт бүхий зөвлөмж өгч, 94.0 хувийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын албаны чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг шинэчлэн батлах тухай” 215 дугаар тушаалаар батлан гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 44,469.7 сая төгрөгөөр буюу 53.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	13,017.5	1,749.2	(11,268.3)

Авлага	24.1	102.3	78.2
Урьдчилгаа	3,177.5	2,372.2	(805.3)
Бараа материал	8,218.5	4,882.5	(3,336)
Үндсэн хөрөнгө	58,074.5	117,875.7	59,801.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>82,512.1</b>	<b>126,981.8</b>	<b>44,469.7</b>
Богино хугацаат өр төлбөр	2,410.1	4,230.7	1,820.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	80,102.0	122,751.1	42,649.1
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>82,512.1</b>	<b>126,981.8</b>	<b>44,469.7</b>

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо зэрэг данснууд байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,749.2 сая төгрөг болж, 11,268.3 сая төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +, Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	117.9	1,749.2	1,631.3
Төгрөг	117.9	1,749.2	1,631.3
Төрийн сангийн харилцах	117.9	1,749.2	1,631.3
Бусад төсөл, нөөцийн харилцах	12,899.6	-	(12,899.6)
<b>Дүн</b>	<b>13,017.5</b>	<b>1,749.2</b>	<b>(11,268.3)</b>

/сая төгрөгөөр/

Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Урсгал төсвийн харилцах данс, хөрөнгө оруулалтын данс, нэмэлт санхүүжилтийн данс, ахмадын дансны үлдэгдэл 2025 оны эцэст улсын төсөвт төвлөрүүлэхээр татагдсан байна.

Хөрөнгө оруулалтын барьцаа дансанд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад Шүүгчийн захирамжаар хэргийн оролцогчоос барьцаа дансанд байршуулсан 1,749.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсныг санхүүгийн байдлын тайланд мөнгөн хөрөнгө хэсэгт тусган харуулсан байна.

#### Аудитын илрүүлэлт

- Орхон аймаг дахь ШТГ анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, нотлох баримтгүй 3.4 сая төгрөгийн сургалт зохион байгуулсан;
- Дундговь аймаг дахь ШТГ 2.8 сая төгрөгийн, Орхон аймаг дахь ШТГ 2.5 сая төгрөгийн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба 2.2 сая төгрөгийн, Говь-Алтай аймаг дахь ШТГ 1.0 сая төгрөгийн, Говьсүмбэр аймаг дахь ШТГ 0.7 сая төгрөгийн цалин, урамшууллыг тус тус давхардуулан, илүү олгосон;
- Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн ИХАШТШТГазар 0.9 сая төгрөгийн цалингаас суутгасан шүүхийн шийдвэрийн суутгалыг холбогдох байгууллага руу шилжүүлээгүй;
- Орхон аймаг дахь ШТГ 3.7 сая төгрөгийн, Сэлэнгэ аймаг дахь ШТГ 1.9 сая төгрөгийн зардлыг бүлэг хооронд зөвшөөрөлгүй зарцуулсан;
- Говь-Алтай аймаг дахь ШТГ ахмадын сантай боловч нэг удаагийн тэтгэмж урамшуулалын зардлаас 4.6 сая төгрөгийн тэтгэмжийг ахмадуудад олгосон.

### 3.4.2 Авлага

Авлага дансны үлдэгдэл 102.3 сая төгрөг болж, 78.2 сая төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +, Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон авлага	18.6	4.9	(13.7)
Татаас, санхүүжилтийн авлага	-	62.7	62.7
Байгууллагаас авах авлага	1.1	2.5	1.4
Хувь хүмүүсээс авах авлага	4.4	16.1	11.7
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	16.1	16.1
<b>Дүн</b>	<b>24.1</b>	<b>102.3</b>	<b>78.2</b>

Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Авлага 78.2 сая төгрөгөөр өссөн нь нэмэлт санхүүжилт болон ахмадын дансны үлдэгдлийг Сангийн яамнаас оны эцэст татаж, татаас санхүүжилтийн авлага үүссэнтэй холбоотой байна.

Урсгал санхүүжилтээс 2 байгууллагад 2.7 сая төгрөг, нэмэлт санхүүжилтээс 2 байгууллагад 17.5 сая төгрөг, ахмадын дансны татан төвлөрүүлсэн үлдэгдлээс 17 байгууллагад 42.3 сая төгрөгийг тус тус Сангийн яамнаас 2026 онд буцаан олгохоор болсон тул татаас санхүүжилтийн авлагаар тусгасан байна.

#### Аудитын илрүүлэлт

- Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн ИХАШТШТГазар 13.7 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;

### 3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны үлдэгдэл 2,372.2 сая төгрөг болж, 805.3 сая төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +, Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	2,922.7	2,372.2	(550.5)
Урьдчилгаа тооцоо	254.8	-	(254.8)
<b>Дүн</b>	<b>3,177.5</b>	<b>2,372.2</b>	<b>(805.3)</b>

Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Урьдчилгаа дансны үлдэгдэлд дараах байгууллагуудад материаллаг хэмжээний өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

- Анхан болон давж заалдах шатны 505 шүүгчийн цахим шуудан, домэйн нэрийн үйлчилгээний дараагийн тайлант оны эхний 5 сард ногдох төлбөр болох 15.3 сая төгрөгийг урьдчилж гарсан зардалд бүртгэсэн;
- Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны тойргийн шүүх нь 2025 оны 1 дүгээр сарын 1-нээс үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд уг шүүхийн

хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор хийсэн засварыг урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн ба гэрээнд заасан үлдэх хугацааны 753.2 сая төгрөг, тус шүүхийн түрээсийн төлбөрийн дараагийн тайлант оны эхний 2 сард ногдох 440.0 сая төгрөгийг тус тус бүртгэсэн;

- Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-д “Шүүгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалын хураамжийг улсын төсвөөс хариуцна” гэж заасны дагуу шүүгчийн амь нас эрүүл мэндийн даатгалын хураамжийг урьдчилж гарсан зардал дансанд бүртгэсэн ба 466.0 сая төгрөг нь дараагийн тайлант оны эхний 5 сард хамаарах тул тус дансанд бүртгэсэн;
- Анхан болон давж заалдах шатны шүүхэд ашиглагдаж буй лицензийн төлбөрийн хураамжийг урьдчилж гарсан зардалд бүртгэсэн бөгөөд дараагийн тайлант онд хамаарах 687.1 сая төгрөгийг тус дансанд бүртгэсэн байна.

### 3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 4,882.4 сая төгрөг болж, 3,336.1 сая төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +, Бууралт (-)
Бичиг хэргийн материал	291.7	274.0	(17.7)
Аж ахуйн материал	1,069.2	1,218.7	149.5
Сэлбэг хэрэгсэл	75.5	64.8	(10.7)
Түлш, шатах тослох материал	62.5	101.1	38.6
Барилгын засварын материал	30.0	23.6	(6.4)
Бусад хангамжийн материал	6,687.0	3,198.2	(3,488.8)
Мал амьтад	2.6	2.0	(0.6)
<b>Дүн</b>	<b>8,218.5</b>	<b>4,882.4</b>	<b>(3,336.1)</b>

Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Бараа материал 3,336.1 сая төгрөгөөр буурсан нь Шүүхийн цөм систем буюу цахим-02 хэрэгжихтэй холбоотой системийн сервер тоног төхөөрөмж бүртгэлтэй байсныг Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаруу шилжүүлсэнтэй холбоотой байна.

#### Аудитын илрүүлэлт

- Архангай аймаг дахь ШТГ анхан шатны баримт бүрдэл хангалтгүй, нотлох баримтгүй 2.8 сая төгрөгийн бараа материал худалдан авсан;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба 4.7 сая төгрөгийн, Дорноговь аймаг дахь ШТГ 0.2 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл тус тус худалдан авсан;
- Хөвсгөл аймаг дахь ШТГ малыг нас дэвшүүлэн бүртгэхдээ 0.6 сая төгрөгийн нийт дүнгээр зарлагдаж орлогодсон, аж ахуйн материал дансанд 2.1 сая төгрөгийн тавилга, 0.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бүртгэсэн;
- Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн ЭХАШТШТГазар 17.5 сая төгрөгийн 4-12 сарын шатахууны тооцоо бодсон акт үйлдээгүй, Говьсүмбэр аймаг дахь ШТГ 0.4 сая төгрөгийн шатахуун зарцуулалтын жишиг норм мөрдөөгүй;

- Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн ЭХАШТШТГазар 26.8 сая төгрөгийн, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн ЭХАШТШТГазар 24.7 сая төгрөгийн, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн ИХАШТШТГазар 10.9 сая төгрөгийн бараа материалын нөөцийг их хэмжээгээр бэлтгэсэн байна.

### 3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл цэвэр дүнгээр 117,875.7 сая төгрөг болж, 59,801.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +, Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>52,693.3</b>	<b>101,453.6</b>	<b>48,760.3</b>
Барилга, байгууламж, орон сууц	31,279.0	30,437.6	(841.4)
Авто-тээврийн хэрэгсэл	2,692.5	5,557.2	2,864.7
Машин тоног төхөөрөмж	9,277.1	13,466.2	4,189.1
Тавилга, аж ахуйн эд хогшил	3,885.4	8,059.6	4,174.2
Зам, гүүрний байгууламж	11.4	10.0	(1.4)
Бусад үндсэн хөрөнгө	426.4	380.6	(45.8)
Дуусаагүй барилга, байгууламж	5,008.4	43,428.5	38,420.1
Ном	113.1	113.7	0.5
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>5,381.2</b>	<b>16,422.1</b>	<b>11,040.9</b>
Програм хангамж	436.6	11,270.7	10,834.1
Бусад биет бус хөрөнгө	4,944.6	5,151.4	206.8
<b>Дүн</b>	<b>58,074.5</b>	<b>117,875.7</b>	<b>59,801.2</b>

Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

- Үндсэн хөрөнгийн өсөлт нь 2025 онд зарим шүүхийн тавилга тоног төхөөрөмжийг шинэчилсэн, шинээр байгуулагдах Гэр бүл хүүхдийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн Тамгын газрын тоног төхөөрөмж тавилгыг худалдан авсан, Шүүхийн цөм систем буюу цахим-02 хэрэгжилттэй холбоотой системийн сервер тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөнд бүртгэсэн;
- ТӨБЗГ-ын шийдвэрээр ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг цаашид нэг, хоёр жил ашиглахаар хугацааг нь сунгасан;
- Дүүргүүдийн шүүхийн нэгдсэн байр үргэлжлэн баригдсан, нийслэл болон орон нутаг дахь 5 шүүхийн байр шинээр баригдаж эхэлснээр дуусаагүй барилга, байгууламжийг 38,420.1 сая төгрөгөөр нэмж бүртгэсэн нь тус тус нөлөөлсөн байна.

#### Аудитын илрүүлэлт:

- Өмч хамгаалах байнгын зөвлөл, тооллогын ажлын хэсгийн үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих хяналт хангалтгүй, хөрөнгийн эцсийн үлдэгдлийг эд хариуцагчийн карттай тулгаж тоолоогүй, тооллогыг бодитой, үр дүнтэй зохион байгуулаагүй дараах газрууд байна. Үүнд: Орхон аймаг дахь шүүхийн Тамгын газар, Баянзүрх, Сүхбаатар,

Чингэлтэй дүүргийн ИХАШТШТГазар, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн ЭХАШТШТГазар, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн ЭХАШТШТГазар;  
 - Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн ЭХАШТШТГазар, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн ИХАШТШТГазар хөрөнгийн тооллогын комиссд нягтлан бодогчийг оруулсан.

### 3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны үлдэгдэл 4,230.8 сая төгрөг болж, 1,820.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +, Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	39.4	33.5	(5.9)
Байгууллагад төлөх өглөг	39.1	2,263.7	2,224.6
Бараа, үйлчилгээний зардлын өглөг	0.1	131.5	131.4
Хувь хүмүүст өгөх өглөг	2,331.6	1,802.1	(529.5)
<b>Дүн</b>	<b>2,410.2</b>	<b>4,230.8</b>	<b>1,820.6</b>

Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Өр төлбөр 1,820.6 сая төгрөгөөр өссөн нь 2025 оны эцэст улсын төсвийн орлогын тасалдал үүссэнтэй холбоотойгоор Сангийн яамнаас санхүүжилт олгогдоогүй, үүний улмаас тендерээр шалгарсан болон зарим шууд худалдан авалтын гэрээний төлбөр хийгдээгүйтэй холбоотой байна.

#### Аудитын илрүүлэлт:

- Дундговь аймаг дахь ШТГ 2.4 сая төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Төсвийг зохистой удирдаагүйгээс Төв аймаг дахь ШТГ 27.0 сая төгрөг, Орхон аймаг дахь ШТГ 34.9 сая төгрөгийн өр төлбөр тус тус үүсгэсэн байна.

### 3.4.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 122,751.1 сая төгрөг болж, өмнөх оноос 42,649.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +, Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	21,988.6	23,889.8	1,901.2
Хуримтлагдсан үр дүн	45,087.6	85,915.9	40,828.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	13,025.8	12,945.4	(80.4)
<b>Дүн</b>	<b>80,102.0</b>	<b>122,751.1</b>	<b>42,649.1</b>

Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Засгийн газрын хувь оролцооны данс 42,649.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны 42,668.5 сая төгрөгийн үр дүн нөлөөлсөн байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгийг ирүүлэх үүрэгтэй.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайланд хамаарах тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийг нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр, тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга, нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулгыг хавсаргаж ирүүлсэн байна.

#### **3.5.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төлөвлөлт**

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 420,800.6 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 510.0 сая төгрөг, зарлагыг 421,310.6 сая төгрөгөөр тус тус тооцон төлөвлөж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Төсвийн төслийг хянаж, хөрөнгийн зардлыг 67,039.5 сая төгрөгөөр, урсгал зардлыг 276,428.7 сая төгрөгөөр, нийт 343,468.2 сая төгрөгөөр баталсан байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд орсон өөрчлөлтөөр төсвийг 67,161.7 сая төгрөгөөр тодотгол хийж 276,306.5 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагч Сангийн яамны зөвшөөрлөөр төсөвт 6 удаагийн 13,894.3 сая төгрөгийн зохицуулалт хийсэн байна. Сангийн яамны 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-д заасны дагуу төсвийн захирагч, зардлын эдийн засгийн зүйл, хөтөлбөр, арга хэмжээний ангиллын дагуу төсөвт зохицуулалт хийсэн байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

##### **Улсын төсвийн орлого бүрдүүлэлт**

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга 2025 онд улсын төсөвт 270.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тооцон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад төсвийн төсөл хүргүүлснийг 240.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 510.0 сая төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсөвт 155.9 сая төгрөг төвлөрүүлж, 30.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

**Хүснэгт 10. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэл**

/сая төгрөгөөр/

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэл (хувь)
1	Шүүхийн тусгай архивын үйлчилгээний хураамж	510.0	155.9	354.1	30.6
	<b>Нийт дүн</b>	<b>510.0</b>	<b>155.9</b>	<b>354.1</b>	<b>30.6</b>

Үүнээс шүүхийн тусгай архивын үйлчилгээний орлого 69.4 хувь буюу 354.1 сая төгрөгөөр буурсан нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт орж, шүүхийн архиваас тусгайлан тодорхойлолт гаргахгүй болсонтой холбоотой байна.

**Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн зарцуулалт**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс урсгал санхүүжилт 195,786.9 сая төгрөг, хөрөнгийн санхүүжилт 44,373.4 сая төгрөг, нийт 240,160.3 сая төгрөгийн санхүүжилт авч, 233,536.3 сая төгрөгийг зарцуулан 6,624.0 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 233,536.3 сая төгрөг буюу 84.5 хувьтай байгаа нь урсгал зардлын төсвийг 34,394.9 сая төгрөг, хөрөнгө оруулалтын төсвийг 8,375.2 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

**Хүснэгт 11. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл**

/сая төгрөгөөр/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувь
<b>I</b>	<b>Шүүх, шүүгчийн хараат бус байдлыг хангах</b>	<b>276,306.5</b>	<b>233,536.3</b>	<b>42,770.2</b>	<b>84.5</b>
1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	204,379.7	183,038.2	21,341.4	89.6
2	80224-Зөвлөл хороо комиссын гишүүдийн ажлын хөлс	200.1	89.1	111.0	44.5
3	80306-Төрийн байгууллага, ажилтны буруутай үйл ажиллагаанаас үүссэн хохирлын нөхөн төлбөр	10.6	10.6	-	100.0
4	80704-Ахмад дайчин, алдар цолтой ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламж	6.6	3.3	3.3	50.1
5	80801-Нөхөн олговор	635.1	634.3	0.8	99.9
6	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	17,661.4	5,131.3	12,530.1	29.1
7	80811-Нүүлгэн шилжүүлэх зардал	33.0	13.0	20.0	39.4
8	80918-Бусад (Хөрөнгө оруулалт)	52,748.6	44,373.4	8,375.2	84.1
9	81569-Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	393.3	118.6	274.7	30.2
10	82321-Шинжээч, орчуулагч, хэлмэрчийн зардал	236.8	124.5	112.3	52.6
11	82322-Гэрчийн зардал	1.3	-	1.3	0.0
	<b>Нийт дүн</b>	<b>276,306.5</b>	<b>233,536.3</b>	<b>42,770.2</b>	<b>84.5</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 245 дугаар тушаалаар 2025 онд улсын төсвөөс 89,731.2 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар батлагдсанаас хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 62,984.5 сая төгрөг, урсгал төсвийн зардалд 26,746.7 сая төгрөг төлөвлөсөн байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2025 оны 119 дүгээр тушаалаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 694.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн шинэчлэн баталсан байна.

2025 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шүүхийн Тамгын газрын 5 барилга, хоёр төрлийн 28 автомашин, 835 ширхэг ширээний компьютер болон бусад тоног төхөөрөмжийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гүйцэтгэлийг хангуулан ажилласан байна. Тухайлбал:

Тайлант онд 10,629.6 сая төгрөгийн 18 төсөл, арга хэмжээг нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар, 977.8 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээг тендер шалгаруулалтын онцгой журам харьцуулалтын аргаар зохион байгуулж гүйцэтгэлээр 11,863.3 сая төгрөгийн 31 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэн санхүүжүүлсэн байна.

Улсын төсвийн орлого буурсан мөн тендер шалгаруулалтын үнэлгээний хорооны шийдвэр дээр гомдол гарсан зэргээс хамааран 7,520.0 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээ цуцлагдаж улсын төсөвт буцаан татан төвлөрүүлсэн байна.

#### Аудитын илрүүлэлт

- Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 149.8 сая төгрөгийн 11 бараа, ажил үйлчилгээг худалдан авсан;
- Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн ЭХАШТШТГазар 74.9 сая төгрөгийн, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн ИХАШТШТГазар 73.9 сая төгрөгийн, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн ЭХАШТШТГазар 42.8 сая төгрөгийн бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай байгуулсан гэрээ дүгнээгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй ААН-д санхүүжилтийг тус тус бүрэн олгосон;
- Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн ИХАШТШТГазар 39.2 сая төгрөгийн, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн ЭХАШТШТГазар 34.2 сая төгрөгийн, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн ИХАШТШТГазар 31.2 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, гүйцэтгэх ажлын тоо хэмжээ, батлагдсан төсөвгүй ажлыг зардлаар бүртгэсэн.

### 3.5.4 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 01 дүгээр хавсралтаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын тайлант онд хэрэг маргааныг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэх хувийг 75.8 байхаар, түүний хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг баталжээ.

Гүйцэтгэлээр нийт 119,747 хэрэг шийдвэрлэснээс 90,987 хэрэг хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн бөгөөд энэ нь 75.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 113 арга хэмжээний 87 арга хэмжээ 85-100 хувь буюу бүрэн хангалттай, 7 арга хэмжээ 70-85 хувь буюу хангалттай, 8 арга хэмжээ 30-50 хувь буюу хангалтгүй үнэлэгдсэн бол 9 арга хэмжээ хэрэгжилт тооцох боломжгүй үнэлэгдэж 91 хувийн биелэлттэй байна.

### **3.5.5 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шүүгч нарыг хэвийн ажиллах нөхцөлөөр хангах болон шүүхийн захиргааны ажилтанд олгох орон нутгийн нэмэгдэлд 2,367.6 сая төгрөг, байрны түрээсийн орлого, оюутны дадлагын орлого, тендерийн орлого, Архивын ерөнхий газраас архив хариуцсан гэрээт ажилтны цалин гэх мэт 18.6 сая төгрөг, нийт 2,386.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр шүүхийн захиргааны ажилтанд орон нутгийн нэмэгдэл болон архив хариуцсан гэрээт ажилтны цалин, НДШ-д 1,749.6 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 69.1 сая төгрөг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын шүүх хуралдааны танхим, шүүгдэгчийн болон хүүхдийн өрөө тохижуулах зориулалтаар тавилга, тоног төхөөрөмж авах мөн өрөө тасалгааны засварт 490.9 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил үйлчилгээний төлбөр хураамж болон бараа үйлчилгээний бусад зардалд 55.0 сая төгрөг, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулалд 1.0 сая төгрөг нийт 2,365.6 сая төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 20.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **Судалгааны үр дүн**

Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний шалгагдагч байгууллагуудаас авсан судалгааны үр дүнг тайланд тусгалаа. Тухайлбал:

- Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн “Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ” гэж заасны дагуу тус салбарт тайлант онд орон тооны цомхотгол хийгдээгүй ба 2026 онд орон тооны цомхотгол хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2025 оны төсвийн төслийн эцсийн хувилбарт орон тоог 2600 байхаар хянасан бөгөөд Төсвийн тухай хууль батлагдахад 2,415 орон тоотой ажиллах цалингийн сан батлагдсан. Тайлант оны 7 дугаар сард 2,230 орон тоотой үйл ажиллагаа явуулж байснаас төсвийн тодотголоор батлагдсан орон тоог 216-аар бууруулж 2,199 болгон цалингийн зардлаас 8,000.сая төгрөг хасагдсан байна.

Цалингийн зардалд төсвийн тодотголоор 146,253.6 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 2,226 орон тоотой 139,474.0 сая төгрөг зарцуулсан байна. 2026 онд салбарын хэмжээнд 32 орон тоог бууруулах эсэх талаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам”-ын 8 дугаар зүйлийн 8.2, 8.4 дэх хэсэгт заасны дагуу төсвийн шууд захирагч нар тушаал гарган алба хаагчдын 1 өдрийн хоолны хөнгөлөлт 32.0 мянган төгрөг хүртэл, унааны хөнгөлөлт 5.0 мянган төгрөг хүртэл тогтоож, харилцан адилгүй байдлаар олгож байна. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын төсөв 12,176.4 сая төгрөгөөр батлагдаж, 11,282.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.
- Сургалт, семинарын зардалд 356.8 сая төгрөг зарцуулсан байна.
- Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс байгуулахтай холбогдуулан Австралийн Холбооны Улсын Гэр бүлийн шүүхийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах томилолтын зардалд 145.7 сая төгрөгийн төсөв батлагдаж 128.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.
- Шүүхийн нээлттэй ил тод байдлыг хангах, шүүхийн мэдээллийг олон нийтэд хүргэх ажлын хүрээнд 124.6 сая төгрөгийг зарцуулсан байна.
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудаас төрд учирсан хохиролтой холбоотой 3 удаагийн 644.9 сая төгрөгийн зардал гарсан байна.
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад Санхүү, нягтлан бодох бүртгэлийн 4, тооцоолол программ хөгжүүлэлтийн 3, алдаа шалгагч бичиг хэргийн 3, аюулгүй байдал, системийн 4, видео хурал, харилцаа холбооны 3, веб сайт, домэйн 9, шүүхийн үндсэн систем 14, бусад 4 нийт 44 лиценз, программ, сайт ашиглагдаж байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын

хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсвийн ерөнхийлөн захирагч түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын аудитор Д.Батчимэг, Э.Булганчимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор Г.Оюунтөгөлдөр, аудитын менежер С.Нацагдорж, Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 01/560 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 145,066.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 1,450.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

##### ***Харьяа байгууллагууд***

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний дүнд:

- Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба - Бичиг хэргийн нэг хүнд ногдох зардлыг 0.9 сая төгрөгөөр бууруулсан;
- Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүхийн Тамгын газар - Цалин, урамшуулал, нормативт зардал, эд хогшил, томилолт, ажил үйлчилгээний зардлыг хэмнэсэн;
- Нийслэлийн Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн Тамгын газар - Эд хогшил, урсгал засвар, бараа үйлчилгээний зардлаас 366.7 сая төгрөгийг хэмнэсэн;
- Нийслэлийн Багахангай, Налайх дүүргийн тойргийн шүүхийн тамгын газар – Үйл ажиллагаа, хангамж, ажил үйлчилгээний зардлаас 105.6 сая төгрөгийг хэмнэсэн;
- Нийслэлийн Багануур дүүргийн шүүхийн Тамгын газар - Үйл ажиллагаа, хангамж, ажил үйлчилгээний зардлаас 212.0 сая төгрөгийг хэмнэсэн;

- Өвөрхангай аймгийн шүүх - Цалин, тогтмол, хангамжийн зардлаас 142.7 сая төгрөгийг хэмнэсэн;
- Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн Тамгын газар - Нормативт ба томилолтын зардлаас 2.3 сая төгрөгийг хэмнэсэн;
- Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн Тамгын газар - Тогтмол, хангамж, томилолт, ажил үйлчилгээний зардлаас 64.1 сая төгрөгийг тус тус хэмнэж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

##### **4.4.1.2 Төсвийн ерөнхийлөн захирагч**

###### **Зөвлөмж**

Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулбал зохих 155 мэдээллээс 6 мэдээг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.1. "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн, үнэн зөв байршуулж хэвших.

##### **4.4.1.3 Түүвэрт хамрагдсан байгууллагууд**

###### **Шүүхийн ерөнхий зөвлөлийн төвлөрсөн төсөв**

###### **Зөвлөмж**

Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулбал зохих 316 мэдээллээс 4 мэдээг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.1. "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т

"тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн, үнэн зөв байршуулж хэвших.

### **Дүүргийн Эрүү, Иргэнийн хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн Тамгын газар**

#### **Зөвлөмж**

**Илрүүлэлт:** Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулбал зохих 2 мэдээг хугацаа хоцроож байршуулсан. Мөн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 526.9 сая төгрөгийн зарлагын 7 гүйлгээг давхардуулан, үнэн зөв мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ: ...6.1.1.тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.10-т "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендэрт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендэрт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн, үнэн зөв байршуулж хэвших.

### **Харьяа байгууллагууд**

#### **Аудитын илрүүлэлт:**

- Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба шилэн дансны цахим хуудсанд байгууллагын батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 10.3 сая төгрөгийн орлогын 1 гүйлгээг мэдээлээгүй;
- Орхон аймаг дахь ШТГ шилэн дансны цахим хуудсанд 25 орлогын гүйлгээ, 1 зарлагын гүйлгээ мэдээлээгүй, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан;
- Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн ИХАШТШТГазар шилэн дансны цахим хуудсанд 70.0 сая төгрөгийн 7 мэдээллийг оруулаагүй, 31 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан;
- Багахангай, Налайх дүүргийн ТШТГ, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн ИХАШТШТГазар, Дорноговь аймаг дахь ШТГ зэрэг байгууллагууд шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан;
- Дархан-Уул аймаг дахь ШТГ шилэн дансны цахим мэдээлэлд 24.0 сая төгрөгийн авлага, өр төлбөрийг мэдээлээгүй;
- Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн ЭХАШТШТГазар шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 403.6 сая төгрөгийн орлогын 6 гүйлгээ, зарлагын 9 гүйлгээг мэдээлээгүй;

## 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

### 4.4.2.1 Төсвийн ерөнхийлөн захирагч

#### Албан шаардлага

Илрүүлэлт: Харьяа байгууллагуудын хууль, тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт сул байгаагаас санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар 1,691.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д "төсвийн ерөнхийлөн захирагч" гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.2.5. өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх дотоод хяналтыг сайжруулан, зөрчлийг бууруулах албан шаардлага хүргүүлэв.

#### Зөвлөмж

Илрүүлэлт: Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалтын удирдамжийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга баталдаг боловч тус газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлтийг ажлын албаны гүйцэтгэх нарийн бичгийн дарга баталж, үнэлдэг бөгөөд чиг үүргийн хувьд Шүүхийн ерөнхий зөвлөлд, бүтэц, зохион байгуулалтын хувьд ажлын албанд харьяалагдаж байна.

Энэ нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т "хяналт шалгалтыг хуульд заасан үндэслэлийн дагуу явуулах бөгөөд энэхүү хяналт шалгалт нь хараат бус, шударга, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх", Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хяналт-шинжилгээ хийх журмын"-ын 2.1-д "Хяналт-шинжилгээг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг тогтмол хугацаанд хэмжих байдлаар дараах зарчмыг баримтлан хийнэ: 2.1.1.шударга, хараат бус байх", 3.2-т "Байгууллага нь хяналт-шинжилгээний асуудал хариуцсан нэгж, эсхүл ажилтан (баг)-тай байх бөгөөд хяналт-шинжилгээний асуудал хариуцсан нэгж, эсхүл ажилтан (баг) нь зохион байгуулалтын хувьд бусад нэгжээс хараат бусаар үйл ажиллагаа явуулна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын удирдлагын харьяаллыг тодорхой болгож, дотоод аудитын хараат бус байдлыг хангах эрх зүйн зохицуулалтыг сайжруулах.

#### 4.4.2.2 Түүвэрт хамрагдсан байгууллагууд Шүүхийн ерөнхий зөвлөлийн төвлөрсөн төсөв

##### Албан шаардлага

Илрүүлэлт: Эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрээс шалтгаалан 2 шүүгчид ажилгүй байсан хугацааны цалин хөлс 634.3 сая төгрөгийг шүүхийн шийдвэрийн дагуу нөхөн олгож, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшууллын зардлаас гаргасан, нөхөн олгосон цалин хөлсийг гэм буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй, өмнөх оны зөрчил давтан гарсан байна.

Энэ нь Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д "Анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийг Ерөнхий зөвлөлийн санал болгосноор, хяналтын шатны шүүхийн шүүгчийг Ерөнхий зөвлөл Улсын Их Хуралд танилцуулснаар Ерөнхийлөгч 14 хоногийн дотор томилно", Захиргааны ерөнхий хуулийн 103.1."Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ", 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна", Төрийн албаны тухай хуулийн 50.1."Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ", Засгийн газрын 2019 оны "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам батлах тухай" 6 дугаар тогтоолд тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шүүхийн шийдвэрээр нэр бүхий 2 иргэнд ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг төсвөөс олгосон асуудлыг судалж, холбогдох хууль журмын дагуу шийдвэрлэх ажлыг зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

##### Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар

##### Зөвлөмж

Илрүүлэлт 1. Тайлант онд 21.7 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртгийг хувааж 2 байгууллагатай шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйл."Төсвийн зарлага"-ийн 24.4 "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион

байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2. Тайлант онд хийгдсэн урсгал засварын ажлыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй байна.

Энэ нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1-д "Худалдан авах ажиллагааны зарчимд нийцүүлэн захиалагч төлөвлөгөөг хуулийн 44 дүгээр зүйл болон энэ журамд заасны дагуу санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан даруйд боловсруулна", 2.8-д "Энэ журмын 1.7-д заасан захиалагчийн гүйцэтгэх удирдлага төлөвлөгөөг батлагдсан төсөв болон хуульд нийцсэн эсэхийг хянан, батална. Захиалагчийн баталгаажуулсан төлөвлөгөөг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш нэг сарын дотор цахим системд нийтэлнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй худалдан авалт зохион байгуулахгүй байх.

## **Дүүргийн Эрүү, Иргэнийн хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн тамгын газар**

### **Зөвлөмж**

Илрүүлэлт: Тайлант онд төсөвт тодотгол хийж, батлагдсан төсөвт өртөг өөрчлөгдсөн боловч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд шинэчлэн батлаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1."Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалын хавсралт "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2 дугаар бүлгийн 2.12."Батлагдсан төлөвлөгөөнд дараах тохиолдлоос өөр үндэслэлээр нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно:...2.12.1.тухайн жилийн төсөвт тодотгол хийсэн, хуульд заасан бусад эх үүсвэр батлагдсан, Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлд зааснаар төсөвт зохицуулалт хийсэн" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсөвт тодотгол хийж, батлагдсан төсөвт өртөг өөрчлөгдсөн тохиолдолд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан нийт төсөвт өртгийг шинэчлэн боловсруулж баталж байх.

Аудитын илрүүлэлт:

- Дорноговь аймаг дахь ШТГ бусад хууль тотоомжтой холбоотой 0.2 сая төгрөгийн зөрчил гаргасан байна.

#### 4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар нийт 3,106.7 сая төгрөгийн 63 зөрчил илэрсэнд 10.9 сая төгрөгийн 7 төлбөрийн акт, 2,450.2 сая төгрөгийн зөрчилд 12 албан шаардлага, 645.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд 44 зөвлөмж хүргүүлснийг 94.2 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Д/д	Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Акт	7	10.9	7	10.9	100.0
2	Албан шаардлага	12	2,450.2	11	2,431.0	91.7
3	Зөвлөмж	44	645.6	40	550.6	90.9
<b>Нийт дүн</b>		<b>63</b>	<b>3,106.7</b>	<b>58</b>	<b>2,992.5</b>	<b>94.2</b>

Худалдан авах ажиллагаатай холбоотой албан шаардлагын биелэлтийг тодорхой тайлагнаагүй, эрх бүхий албан тушаалтны томилгооноос шалтгаалсан нөхөн олговрыг төсвөөс олгосон зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагын биелэлт хангагдаагүй байна.

Шилэн дансны алдаа зөрчил давтагдан гарсан, худалдан авах ажиллагааны зөвлөмжийн биелэлтийг дутуу тайлагнасан тул зөвлөмжийн биелэлт дунджаар 90 хувьтай байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлыг анхаарч үзэх шаардлагатай байна. Тухайлбал:

- Харьяа байгууллагууд буюу төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын хавсралтад заасан маягтын дагуу бэлтгэхээр зохицуулсан боловч “Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн систем” дэх тайлангийн зарим үзүүлэлт хоорондоо зөрүүтэй байгааг цаашид анхаарах нь зүйтэй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 1,446.1 сая төгрөгийн 45 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 939.6 сая төгрөгийн 47 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 12.6 сая төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт тогтоож, 574.6 сая төгрөгийн зөрчилд 19 албан шаардлага хүргүүлж, 352.4 сая төгрөгийн 21 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 939.6 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.1 Харьяа байгууллагууд

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 42 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 25 байгууллагад дүгнэлт гаргаж, 17 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын 24 санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, 1 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Харьяа байгууллагуудад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 743.6 сая төгрөгийн 45 зөрчил илэрснээс, 12.6 сая төгрөгийн 7 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 574.6 сая төгрөгийн 18 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 156.4 сая төгрөгийн 20 зөвлөмж өгсөн.

### 5.2 Төсвийн ерөнхийлөн захирагч

Аудитаар харьяа байгууллагуудад тавих дотоод хяналтыг сайжруулах, зарим асуудлыг хуульд нийцүүлэн судалж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах талаар 1 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлээ.

### Албан шаардлага

Илрүүлэлт: Харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сул байгаагаас тайлант онд нийт 743.6 сая төгрөгийн материаллаг хэмжээний зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д "төсвийн ерөнхийлөн захирагч" гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", 5 дугаар зүйлийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 14 дүгээр зүйлийн 14.2 "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.2.5. өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 14.2.10 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлэв.

### **Зөвлөмж**

Илрүүлэлт: Харьяа байгууллагуудын дансанд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн захирамжаар хэргийн оролцогчоос барьцааны дансанд байршуулсан, өндөр насжилттай барьцааны мөнгийг шийдвэрлэх чиглэлээр зохих арга хэмжээ авч ажиллаагүй байна. Тухайлбал Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн Тамгын газрын санхүүгийн байдлын тайланд бусад хүмүүст төлөх өглөг дансанд 196.0 сая төгрөгийг тайлагнасан байна.

Энэ нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.8 дугаар зүйл. "Барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөнөөс үүсэх үр дагавар 2. Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгосон, эсхүл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болсон бол барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгож, барьцааг буцаан олгоно", 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, Сангийн сайдын 58, А/87, 203 дугаар хамтарсан захирамж, тушаалаар баталсан "Барьцааны мөнгийг байршуулах, шилжүүлэх, шийдвэрлэх журам"-ын 4.3-т Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 32.5 дугаар зүйлд заасан тохиолдолд барьцааны мөнгийг барьцаа гаргагчийн дансанд шилжүүлж, баримтыг хэрэгт хавсаргана", 4.4-т "Шүүхийн шийдвэрийг үндэслэн тухайн шүүхийн тамгын газрын дарга, прокурорын шийдвэрийг үндэслэн тухайн прокурорын газрын тамгын хэлтсийн дарга, сум буюу сум дундын прокурорын газрын ерөнхий прокурор, нягтлан бодогч нар тусгай дансанд байршуулсан барьцааны мөнгөний гүйлгээг хийнэ" гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Барьцааны дансанд байршуулсан, өндөр насжилттай барьцааны мөнгийг шийдвэрлэх чиглэлээр хууль журмын дагуу зохих арга хэмжээ ажиллах.

## **5.3 Түүвэрт хамрагдсан байгууллагууд**

### **5.3.1 Шүүхийн ерөнхий зөвлөлийн төвлөрсөн төсөв**

#### **Зөвлөмж**

Илрүүлэлт 1. Тайлант онд шүүгчдийн чуулганы зардал болон 4 удаагийн урсгал засварын ажилд 24.2 сая төгрөгийг зарцуулсан боловч шаардлагатай төсвийн тооцоо, ажлын даалгавар, гэрээ байгуулах болон гүйцэтгэлийг дүгнэх зэрэг анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг

анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсөв, зардлыг урьдчилсан тооцоо, батлагдсан ажлын даалгавар, гэрээ, гүйцэтгэлийг анхан шатны баримтаар бүрэн баримтжуулж хэвших.

### **5.3.2 Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар**

#### **Албан шаардлага**

Илрүүлэлт: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин 0.4 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна.

Энэ нь төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "үр ашигтай байх", 4.2.1 "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттай зохион байгуулах", 12 дугаар зүйлийн 12.1.4 "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.5 "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж бэлэг дурсгалын зүйл худалдан авдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

### **5.3.3 Дүүргийн Эрүү, Иргэнийн хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн Тамгын газар**

#### **Албан шаардлага**

Илрүүлэлт: Худалдан авах ажиллагаатай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 12 бараа, ажил, үйлчилгээг 42.0 сая төгрөгөөр худалдан авсан;

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тендер шалгаруулалтын аргыг мөрдөж ажиллаагүй нийт 114.7 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн;

Худалдан авах гэрээнд үнийн дүн болон ажил гүйцэтгэх хугацааг тусгаагүй 50.5 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т "Худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг тусгана:...39.3.1.гэрээний үнэ; 39.3.3.төлбөрийн нөхцөл, хугацаа", Иргэний хуулийн 195 дугаар зүйлийн 195.2-т "Гэрээ байгуулах саналд гэрээний гол нөхцөл буюу түүнийг тодорхойлох журмыг заасан байна", Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 3 дугаар бүлгийн 3.9-д "Шууд худалдан авалт

хийсэн захиалагч тухайн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, гэрээний үнийн дүнг цахим системд оруулсан байна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахгүй байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

#### **5.3.4 Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн Тамгын газар**

##### **Албан шаардлага**

Илрүүлэлт: Тайлант онд 38.4 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг хүлээн авсан комиссын акт, гэрээ дүгнэсэн актгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, бүртгэлээр тавих хяналт сул байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1. "Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана" гэж тус тус заасантай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Бараа, ажил, үйлчилгээг хүлээн авсан комиссын акт, гэрээ дүгнэсэн актгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, бүртгэлээр тавих хяналт сул байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

##### **Зөвлөмж**

Илрүүлэлт: Өмч хамгаалах байнгын зөвлөл, тооллогын комисс үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих хяналт сул байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн" 5.1.4-д "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өмч хамгаалах байнгын зөвлөл, тооллогын ажлын хэсгийн үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ****6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт дүн		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Архангай аймаг дахь шүүхийн Тамгын газар	1	4.0			1	4.0	1	4.0
2	Булган аймаг дахь шүүхийн тамгын газар	1	0.0	1	0.0			1	0.0
3	Дундговь аймаг дахь шүүхийн тамгын газар	2	6.4	1	0.1	1	6.3	2	6.4
4	Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газар	3	16.1	2	7.7	1	8.4	3	16.1
5	Дорноговь аймаг Замын-Үүд сум дахь СДШүүхийн тамгын газар	3	9.6	1	0.1	2	9.5	3	9.6
6	Өмнөговь аймаг дахь шүүхийн тамгын газар	1	0.0			1	0.0	1	0.0
7	Ховд аймаг дахь шүүхийн тамгын газар	1	150.0			1	150.0	1	150.0
8	Ховд аймгийн Булган сум дахь СДШүүхийн тамгын газар	2	11.1			2	11.1	2	11.1
9	Баян-Өлгий аймаг дахь шүүхийн тамгын газар	1	90.1			1	90.1	1	90.1
10	Говьсүмбэр аймаг дахь шүүхийн тамгын газар	4	2.0	1	0.1	3	1.9	4	2.0
11	Дархан-Уул аймаг дахь шүүхийн тамгын газар	3	4.8	2	1.8	1	3.0	3	4.8
12	Орхон аймаг дахь шүүхийн тамгын газар	1	4.8	1	4.8			1	4.8
13	Төв аймаг дахь шүүхийн тамгын газар	1	5.2	1	5.2			1	5.2
14	Баянзүрх,Сүхбаатар, Чингэлтэй ИХАШШТГгазар	2	190.0			2	190.0	2	190.0
15	Баянзүрх,Сүхбаатар, Чингэлтэй ЭХАШШТГгазар	5	266.7	2	12.0	3	254.7	5	266.7
16	Баянгол,Хан-Уул,Сонгинохайрхан ИХАШШТГгазар	3	38.6			3	38.6	3	38.6
17	Баянгол,Хан-Уул,Сонгинохайрхан ЭХАШШТГгазар	3	66.8			3	66.8	3	66.8
18	Багахангай, Налайх дүүргийн тойргийн шүүхийн Тамгын газар	2	433.5			2	433.5	2	433.5
19	Багануур дүүргийн шүүхийн тамгын газар	1	0.1			1	0.1	1	0.1
20	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Тамгын газар	2	0.7			2	0.7	2	0.7
21	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар	1	0.3			1	0.3	1	0.3
22	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба	3	145.2	1	1.1	2	144.1	3	145.2
<b>Дүн /харьяа байгууллагууд/</b>		<b>45</b>	<b>1,446.1</b>	<b>13</b>	<b>33.0</b>	<b>32</b>	<b>1,413.1</b>	<b>45</b>	<b>1,446.1</b>
<b>Нийт дүн</b>		<b>45</b>	<b>1,446.1</b>	<b>13</b>	<b>33.0</b>	<b>32</b>	<b>1,413.1</b>	<b>45</b>	<b>1,446.1</b>

## 6.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан санхүүгийн зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт дүн		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	2	196.0			1		1	196.0
	<b>Дүн</b>	<b>2</b>	<b>196.0</b>			<b>1</b>		<b>1</b>	<b>196.0</b>
2	Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн Тамгын газар	1	42.0			1	42.0		
3	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар	1	0.4			1	0.4		
4	Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн Тамгын газар	2	38.4			1	38.4	1	0.0
5	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба	4	156.8	1	2.3	2	154.5	1	0.0
6	Шүүхийн ерөнхий зөвлөлийн төвлөрсөн төсөв	1	24.2					1	24.2
	<b>Дүн /түүврийн байгууллагууд/</b>	<b>9</b>	<b>261.8</b>	<b>1</b>	<b>2.3</b>	<b>5</b>	<b>235.4</b>	<b>3</b>	<b>24.2</b>
7	Дундговь аймаг дахь шүүхийн тамгын газар	2	5.2	1	2.8	1	2.4		
8	Өмнөговь Хан богд сум дахь сум дундын шүүхийн тамгын газар	1	0.0					1	
9	Хөвсгөл аймаг дахь шүүхийн Тамгын газар	3	3.2					3	3.2
10	Архангай аймаг дахь шүүхийн тамгын газар	1	2.8			1	2.8		
11	Говь-Алтай аймаг дахь шүүхийн тамгын газар	2	5.6	1	1.0			1	4.6
12	Говьсүмбэр аймаг дахь шүүхийн тамгын газар	2	1.1	1	0.8			1	0.4
13	Орхон аймаг дахь шүүхийн тамгын газар	6	44.5	3	5.9	1	34.9	2	3.7
14	Сэлэнгэ аймаг дахь шүүхийн тамгын газар	1	1.9			1	1.9		
15	Төв аймаг дахь шүүхийн тамгын газар	1	27.0					1	27.0
16	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй ИХАШШТГазар	6	129.7			4	129.7	2	0
17	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй ЭХАШШТГазар	4	117.1			1	24.7	3	92.4
18	Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан ЭХАШШТГазар	5	103.7			3	103.7	2	0
19	Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан ИХАШШТГазар	2	40.1			1	39.2	1	0.9
	<b>Дүн /харьяа байгууллагууд/</b>	<b>36</b>	<b>481.8</b>	<b>6</b>	<b>10.4</b>	<b>13</b>	<b>339.2</b>	<b>17</b>	<b>132.2</b>
	<b>Нийт дүн</b>	<b>47</b>	<b>939.6</b>	<b>7</b>	<b>12.6</b>	<b>19</b>	<b>574.6</b>	<b>21</b>	<b>352.4</b>

## 6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт дүн		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	3				1		2	
	<b>Дүн</b>	<b>3</b>				<b>1</b>		<b>2</b>	
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал</b>									
2	Орхон аймаг дахь шүүхийн тамгын газар	1	0.0			1	0.0		
3	Дархан-Уул аймаг дахь шүүхийн Тамгын газар	1	24.0					1	24.0
4	Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газар	1	0.0					1	0.0
5	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй ИХАШШТГ газар	1	70.0					1	70.0
6	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй ЭХАШШТГ газар	1	403.6					1	403.6
7	Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан ИХАШШТГ газар	1	0.0					1	0.0
8	Багахангай Налайх дүүргийн шүүхийн тамгын газар	1	0.0					1	0.0
9	Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн Тамгын газар	1	526.9					1	526.9
10	Шүүхийн ерөнхий зөвлөлийн төвлөрсөн төсөв	1	0.0					1	0.0
11	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба	1	10.3			1	10.3		
	<b>Шилэн дансны дүн</b>	<b>10</b>	<b>1,034.9</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>2</b>	<b>10.3</b>	<b>8</b>	<b>1,024.5</b>
<b>Бусад хууль, тогтоомжтой холбоотой асуудал</b>									
12	Говьсүмбэр аймаг дахь шүүхийн тамгын газар	1	0.0					1	0.0
13	Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газар	1	0.2	1	0.2				
14	Дорнод аймаг дахь шүүхийн тамгын газар	1	0.0					1	0.0
15	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба	1	0.0					1	0.0
16	Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн Тамгын газар	1	0.0					1	0.0
17	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар	2	21.7					2	21.7
18	Шүүхийн ерөнхий зөвлөлийн төвлөрсөн төсөв	1	634.3			1	634.3		
	<b>Бусад хууль тогтоомжийн дүн</b>	<b>8</b>	<b>656.3</b>	<b>1</b>	<b>0.2</b>	<b>1</b>	<b>634.3</b>	<b>6</b>	<b>21.7</b>
	<b>Нийт дүн</b>	<b>21</b>	<b>1,691.1</b>	<b>1</b>	<b>0.2</b>	<b>4</b>	<b>644.7</b>	<b>16</b>	<b>1,046.2</b>

## 6.4 Санхүүгийн тайлангийн аудитын хамрагдалт

/тоогоор/

№	Байгууллагын нэр	2025 оны санхүүгийн тайлангийн аудит		Дүгнэлт			
		ҮАГ	АНТАГ	Нийт тоо	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Түүвэрт хамрагдсан
1	ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан	1		1	1		
<b>Тоо /ТЕЗ/</b>		<b>1</b>		<b>1</b>	<b>1</b>		
2	Архангай аймаг дахь шүүхийн тамгын газар		1	1	1		
3	Баян-Өлгий аймаг дахь шүүхийн тамгын газар		1	1			1
4	Баянхонгор аймаг дахь шүүхийн тамгын газар		1	1	1		
5	Булган аймаг дахь шүүхийн тамгын газар		1	1	1		
6	Говь-Алтай аймаг дахь шүүхийн тамгын газар		1	1			1
7	Говьсүмбэр аймаг дахь шүүхийн тамгын газар		1	1			1
8	Дархан-Уул аймаг дахь шүүхийн тамгын газар		1	1	1		
9	Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газар		1	1	1		
10	Дорноговь аймаг Замын-Үүд сум дахь СДШүүхийн тамгын газар		1	1			1
11	Дорнод аймаг дахь шүүхийн тамгын газар		1	1			1
12	Дундговь аймаг дахь шүүхийн тамгын газар		1	1	1		
13	Завхан аймаг дахь шүүхийн тамгын газар		1	1	1		
14	Завхан аймаг Тосонцэнгэл сум дахь СДШүүхийн тамгын газар		1	1	1		
15	Орхон аймаг дахь шүүхийн тамгын газар		1	1	1		
16	Өвөрхангай аймаг дахь шүүхийн тамгын газар		1	1	1		
17	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь шүүхийн Тамгын газар		1	1	1		
18	Өмнөговь аймаг дахь шүүхийн тамгын газар		1	1	1		
19	Өмнөговь Хан богд сум дахь сум дундын шүүхийн тамгын газар		1	1	1		
20	Сүхбаатар аймаг дахь шүүхийн тамгын газар		1	1	1		
21	Сэлэнгэ аймаг дахь шүүхийн тамгын газар		1	1	1		
22	Сэлэнгэ аймаг Мандал сум дахь СДШ-ийн тамгын газар		1	1			1
23	Сэлэнгэ аймаг Сайхан сум дахь СДШүүхийн тамгын газар		1	1			1
24	Төв аймаг дахь шүүхийн тамгын газар		1	1	1		
25	Увс аймаг дахь шүүхийн тамгын газар		1	1	1		

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

26	Ховд аймаг дахь шүүхийн тамгын газар		1	1			1
27	Ховд аймгийн Булган сум дахь СДШүүхийн тамгын газар		1	1			1
28	Хөвсгөл аймаг дахь шүүхийн тамгын газар		1	1	1		
29	Хэнтий аймаг дахь шүүхийн тамгын газар		1	1			1
30	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь СДШүүхийн тамгын газар		1	1			1
31	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй ИХАШШТГ		1	1	1		
32	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй ЭХАШШТГазар		1	1	1		
33	Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан ЭХАШШТГазар		1	1	1		
34	Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан ИХАШШТГазар		1	1	1		
35	Багахангай, Налайх дүүргийн тойргийн шүүхийн Тамгын газар		1	1	1		
36	Багануур дүүргийн шүүхийн тамгын газар		1	1	1		
37	Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн Тамгын газар	1		1			1
38	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Тамгын газар	1		1			1
39	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар	1		1			1
40	Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Тамгын газар	1		1			1
41	Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн Тамгын газар	1		1			1
42	Шүүхийн төвлөрсөн төсөв	1		1			1
43	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба	1		1		1	
<b>Тоо /Харъяа байгууллагууд/</b>		<b>7</b>	<b>35</b>	<b>42</b>	<b>24</b>	<b>1</b>	<b>17</b>
<b>НИЙТ ТОО</b>		<b>8</b>	<b>35</b>	<b>43</b>	<b>25</b>	<b>1</b>	<b>17</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1414/А0111371

Улаанбаатар хот

САГ-2026/29/НА-СТА-ТЕЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Харьяа байгууллагуудын хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт сул байгаагаас санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар 1,691,129,246.00 /нэг тэрбум зургаан зуун ерэн нэгэн сая нэг зуун хорин есөн мянга хоёр зуун дөчин зургаа/ төгрөгийн зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д "төсвийн ерөнхийлөн захирагч" гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.2.5. өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга /П.Золзаяа/, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга /С.Наранбилэг/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Б.Хэрлэнчимэг/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Даваажав/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

СМ  С.МАГНАЙСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1415/А0111371

Улаанбаатар хот

САГ-2026/29/НА - СТА-ТЕЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сул байгаагаас тайлант онд нийт 743,618,860.58 /долоон зуун дөчин гурван сая зургаан зуун арван найман мянга найман зуун жаран төгрөг тавин найман мөнгө/ төгрөгийн материаллаг хэмжээний зөрчил илэрсэн.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д "төсвийн ерөнхийлөн захирагч" гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.2.5. өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 69 дүгээр зүйлийн 69.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн удирдлага, дотоод хяналт, тайлагналын тогтолцоо хангалтгүй байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга /П.Золзаяа/, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга /С.Наранбилэг/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Б.Хэрлэнчимэг/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Даваажав/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



С.МАГНАЙСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264430

Z:\Alban Shaardlaga\2026\0424 SAG-43.Docx

1526182283



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1416/АОМНЗ71

Улаанбаатар хот

САГ-2026/326/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн Төвлөрсөн төсвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрээс шалтгаалан 2 шүүгчид ажилгүй байсан хугацааны цалин хөлс 634,340,826.00 /зургаан зуун гучин дөрвөн сая гурван зуун дөчин мянга найман зуун хорин зургаа/ төгрөгийг шүүхийн шийдвэрийн дагуу нөхөн олгож, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшууллын зардлаас гаргасан, нөхөн олгосон цалин хөлсийг гэм буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй, өмнөх оны зөрчил давтан гарсан байна.

Энэ нь Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д "Анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийг Ерөнхий зөвлөлийн санал болгосноор хяналтын шатны шүүхийн шүүгчийг Ерөнхий зөвлөл Улсын Их Хуралд танилцуулснаар Ерөнхийлөгч 14 хоногийн дотор томилно", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ", 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрээс шалтгаалан 2 шүүгчид ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт олгосон төлбөрийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга /П.Золзаяа/, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга /С.Наранбилэг/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Б.Хэрлэнчимэг/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Дараажав/ нэрт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

С.МАГНАЙСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тоируу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z: Alban Shaardlaga 20260424 SAG-43.Docx

1526182285